



ДОРНОД АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН
ГАЗАР

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2026

МОНГОЛЫН ТҮҮХ Онлайн сорил-2

12 сарын 27 18.00-19.20

1.

1. Жишгийг ажиглаад асуултын тэмдгийн оронд тохирох хариултыг доорх өгөгдлөөс сонгоно уу? /1 оноо/

Мезолит – Нум сумаар ан агнадаг болов.

Неолит - ?

A. Гал гаргаж сурав.

B. Чулуун зэвсэг хийж сурав.

C. Газар тариалан, мал аж ахуй эрхэлдэг болов.

D. Сүлжмэл хувцас хийж өмсөв.

E. Эхийн эрхт овог тогтов.

2.

Монголын хуучин чулуун зэвсгийн үеийн дурсгалт газруудыг зөв харгалзуулна уу? /2 оноо/

1. Цагаан агуй

2. Мойлтын ам

3. Ярх уул

4. Хойд Цэнхэрийн агуй

a. Дундговь аймгийн Гурвансайхан сум

b. Баянхонгор аймгийн Баянлиг сум

c. Ховд аймгийн Манхан сум

d. Өвөрхангай аймгийн Хархорин сум

A. 1b, 2c, 3d, 4a

B. 1b, 2d, 3a, 4c

C. 1c, 2d, 3a, 4b

D. 1a, 2b, 3c, 4d

E. 1d, 2b, 3a, 4c

3. Буган хөшөөнд байдаг нийтлэг дүрслэл аль нь вэ?

/1 оноо/

- A. Буга, сэлэм, бамбай, нум сум
- B. Сүрлэг, гоёмсог эвэртэй буга
- C. Буга агнаж буй хүмүүс
- D. Малгай, ташуу энгэртэй дээл, аяга, гутал
- E. Нар сар, буга, бүс, зэр зэвсэг

4. Хүрэл, түрүү төмрийн үеийн археологийн дурсгалд аль нь хамаарах вэ?

/1 оноо/

- A. Чулуун зэвсгийн суурин
- B. Хот суурины туурь
- C. Хүн чулуу
- D. Буган хөшөө
- E. Зэл чулуу

5. Монгол нутгаас хазаарын амгай зуузай, оломны арал, шахуурга, бөгж, хүрэл даруулга зэрэг мал аж ахуйн тоног хэрэглэл маш их олддог. Энэ нь юуг илэрхийлж байна вэ? /2 оноо/

- A. Бод, бог малыг уналга, ачилгат ашиглаж эхэлснийг
- B. Мал аж ахуйн хөгжлийг
- C. Газар тариалан эрчимтэй хөгжсөнийг
- D. Төр улсын хөгжлийг
- E. Гар урлал, газар тариалан өндөр хөгжсөнийг

6.

Модунь шаньюйн түүхэн гол үйл явдлуудыг зөв дараалалд оруулсан нь аль вэ? /1 оноо/

1. Өмнөд хөрш Хан улс руу довтлов.
2. Улсаа баруун, зүүн, төв гэсэн гурван хэсэгт хуваан захирав.
3. Хүннүгийн шаньюй болов.

A. 3, 1, 2

B. 2, 1, 3

C. 1, 2, 3

D. 3, 2, 1

E. 2, 3, 1

7.

7. Хан улсын хуанди, Хүннүгийн шаньюйд “Урт цагаан хэрмээс хойшхи нум сум агсагчдын улс нь шаньюйн зарлигийг дагаж, Цагаан хэрэмнээс урагш түшмэдийн бүс, малгай өмсөгчид суудаг орон нь харин надад захирагдана” хэмээх сурвалжийн мэдээний гол агуулгыг зөв тодорхойлсон нь аль вэ? /2 оноо/

A. Хоёр улс худалдаа хийхээр тохиролцсон

B. Хан улс, Хүннү улсад бүрмөсөн бууж өгсөн

C. Хүннү улс, Хан улсын найрсаг харилцаа тасарч, дайны байдалд шилжсэн

D. Хан улс Хүннү улсыг хүлээн зөвшөөрч, Цагаан хэрмээр хилээ тогтоосон

E. Хүннү нар хүчирхэг нум сумт цэрэгтэй байсан

8.

Сяньби улс хүчирхэг байсныг нотлох сурвалжийн мэдээ аль нь вэ?

/1 оноо/

A. Сяньби улсын цэргийн тоо 500.000-д хүрчээ.

B. Малынхаа тоог өсгөж, үүлдэр угсааг нь сайжруулж байв.

C. Умард Хүннүгийн зарим хүн амыг өөртөө нэгтгэжээ.

D. Гар урлал, газар тариалан эрчимтэй хөгжиж байв.

E. Тэдний зэвсгийн хурц, морины хурдан нь Хүннү нарынхаас нэн хэтийджээ.

9.

9. “Хожуу Хань улсын судар”-т: “Хүлэг морь унах, харвах намнахдаа гарамгай, ан гөрөө хийж аж төрнө. Өвс усны сайныг дагаж мал маллана” хэмээх сурвалжийн мэдээ аль үеийн монголчуудын ахуй амьдралын тухай өгүүлсэн байна вэ? /1 оноо/

- A. Монголын эртний улсуудын үеийн
- B. Шинэ чулуун зэвсгийн үеийн
- C. Шинэ үеийн
- D. Манжийн эрхшээлийн үеийн
- E. Дунд үеийн

10.

10. Хүннүгийн үеийн археологийн дурсгалд аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/

- A. Хадны зураг
- B. Язгууртны булш
- C. Хот суурин
- D. Хиригсүүр
- E. Жирийн иргэдийн булш

11.

11. Хамгийн анх судлагдсан Ноён уулын Хүннүгийн язгууртны булш аль аймгийн ямар суманд байдаг вэ? /1 оноо/

- A. Өвөрхангай аймгийн Богд сум
- B. Төв аймгийн Батсүмбэр сум
- C. Ховд аймгийн Манхан сум
- D. Архангай аймгийн Хайрхан сум
- E. Хэнтий аймгийн Баян-Адарга сум

12.

12. Хятад сурвалж дахь “Жужан нарын үсэг бичиг нь Хүннү нарынхтай төстэй” хэмээх мэдээнд хийсэн дүгнэлтүүдээс аль нь оновчтой байна вэ? /2 оноо/

- A. Хүннү нар Монгол бичгийг анх зохиосон
- B. Жужан нар Хүннүгийн удам болохыг баталдаг
- C. Хүннү, жужанчууд соёлын харилцаатай байсан
- D. Жужаны бичиг үсгийг Хүннү нар өвлөн авсан
- E. Хүннүчүүд бичиг үсэгтэй байсныг харуулна

13.

13. “Чингис хааны дээд язгуур. Дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу. Гэргий нь Хоо марал ажээ. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ Бурхан халдунаа нутаглаж ...” хэмээн ямар сурвалжид бичсэн байдаг вэ? /1 оноо/

- A. Монголын нууц товчоо
- B. Юань улсын судар
- C. Гильом де Рубрукын Дорно этгээдэд зорчсон минь
- D. Рашид ад-Диний Судрын чуулган
- E. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх

14.

Татар улс Хятан улсын цэрэгт цохигдсон 923 оныг зууны тоололд шилжүүлнэ үү?

/2 оноо/

- | | | |
|-----------------------|------------------------|--------------------|
| A. X зууны II хагас | B. IX зууны I хагас | C. X зууны I хагас |
| D. VIII зууны I хагас | E. VIII зууны II хагас | |

15.

НТ VI зууны дунд үед Жужан улсын хүн ам гурав хуваагдсан шалтгаан юу вэ? /2 оноо/

- A. Жужан улсад их ган зуд болсон
- B. Түрэгүүд Жужан улсыг мөхөөж, Монгол нутгийг эрхшээлдээ оруулсан
- C. Жужан улсын хүн ам нэмэгдсэн
- D. Малын бэлчээр нь багассан
- E. Жужан улсад нэгэн зэрэг гурван хаан гарч ирсэн

16.

Их Монгол улсын алтан ургийн “Их эе”-ийн хэлэлцэх асуудалд аль нь орохгүй вэ?

/1оноо/

- A. Төрийн чухал асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргах
- B. Дайн хийх
- C. Их хааны залгамжлагчийг сонгох
- D. Аравтын ноёдыг томилох
- E. Дээрх бүгд зөв

17.

17. Монголын Цагаадайн улсын газар нутаг нь одоогийн ямар ямар улсын газар нутгийг хамарч байсан бэ? /1 оноо/

- A. Азербайжан, Армен, Иран, Ирак, Турк
- B. Афганстан, Энэтхэг, Гүрж, Армен
- C. Казакстан, Узбек, Киргиз, Тажик, Хятадын Шинжааны ихэнх хэсэг
- D. Монгол, Хятад, Солонгос, Бирм, Аннам
- E. Казакстан, Узбек, Киргиз, Иран, Орос

18.

18. Монголын Их Юань улсын үед “Монгол хүнийг тэргүүнд тавьж, дараа нь өнгөт нүдтэн хэмээгдэх уйгур, араб, перс хүмүүсийг, гуравт умард Хятад дахь зүрчид, хятан нар, хамгийн доор өмнөд хятадын нанхиад нар” гэсэн дөрвөн зэрэглэлд хүн амаа хуваасны шалтгаан юу вэ ? /2 оноо/

- A. Буддын шашны хос ёсны бодлогоор
- B. Төрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор
- C. Улсын дотоод эв нэгдлийг хангах үүднээс
- D. Монголчууд бусад үндэстнээс олон байсан
- E. Үндэстэн хоорондын мөргөлдөөнөөс сэргийлж

19.

Төгстөмөр (Усгал) хаан хэдээс хэдэн оны хооронд төр барьж байсан бэ? /1 оноо/

- A. 1389-1392 он
- B. 1368-1370 он
- C. 1333-1370 он
- D. 1370-1378 он
- E. 1378-1388 он

20.

Дөрвөн Ойрадын Торгуудын ноёд язгууртнууд хэний угсааных вэ? /1 оноо/

- A. Хэрэйдийн Ван ханы
- B. Ойрадын Хутуг бэхийн
- C. Чингис хааны дүү Хавт Хасарын
- D. Чингис хааны хөвгүүн Тулуйн
- E. Ойрадын Эсэн тайшийн

21.

21. XV-XVI зууны үеийн Зүүн Монголын жононгийн толгойлдог Баруун гурван түмэнг зөв ялгасан хувилбар аль вэ? /2 оноо/

- | | | | | | |
|------------|----------|----------|------------|-------------|------------|
| 1. Халх | 2. Ордос | 3. Түмэд | 4. Цахар | 5. Урианхай | 6. Юншээбү |
| A. 1, 2, 3 | | | B. 2, 4, 5 | | C. 1, 4, 5 |
| D. 2, 3, 6 | | | E. 4, 5, 6 | | |

22.

“Монгол-Ойрадын их цааз” хуулийг баталсан чуулган хаана болсон бэ? /1 оноо/

A. Тарвагатайн Улаан бураа

B. Ширээ Цагаан нуур

C. Хөхнуур

D. Ар Элстэй

E. Долоон нуур хот

23.

Лигдэн хааны гадаад бодлогын үйл ажиллагаанд аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/

A. Мин улсын Гуаннин хотыг довтлов.

B. Авга хар ууланд Очир Цагаан хот байгуулав.

C. Мин улсаас жил бүр 1000-81000 хүртэл лан мөнгөний татаас авах болов.

D. Тиелин даваанд Манжийн цэрэгтэй тулалдав.

E. Мин улстай холбоо тогтоож, худалдаа хийхийг зөвшөөрүүлэв.

24.

24. XVI зууны үед Монгол гэрийн төрх, хэлбэр, хэмжээ нь эрт, дундад үеийнхээс өөрчлөгдөж, одоогийн төрхийг олжээ. Тэгвэл гэрийн хэлбэрт ямар өөрчлөлт гарсан бэ? /1 оноо/

A. Гэрийн гадна талыг хээ угалзаар чимэглэх болсон

B. Гэрийн хаалганы хавтсыг модоор хийдэг болсон

C. Хаад ноёд гоёмсог сийлбэр бүхий гэр хэрэглэх болсон

D. Ханын толгой нэмэгдэж, цамхраат тооно бий болсон

E. Монгол гэр бөмбөгөр, дугуй хэлбэртэй болсон

25.

25. Долоон нуурт болсон Халх Монголыг Манжид дагаар оруулах чуулганд хэн нь оролцоогүй вэ? /1 оноо/

A. Хотгойдын Чингүнжав

B. Өндөр гэгээн Занабазар

C. Сэцэн хан Өмөхэй

D. Түшээт хан Чахундорж

E. Засагт ханы угсааны ноёд

26.

26. XVII-XVIII зууны үеийн Ойрад Монголын түүхэн үйл явдлуудыг зөв харгалзуулсан хувилбарыг олно уу? /2 оноо/

- | | |
|--|------------|
| 1. Галдан бошогт цэргийн хүчээр Халхад довтлов. | a. 1676 он |
| 2. Зүүнгар улсын хаан Даваач Манжийн цэрэгт ялагдав. | b. 1745 он |
| 3. Галдан бошогт Зүүнгар улсыг байгуулав. | c. 1688 он |
| 4. Галданцэрэн хаан нас барж, дотоодын зөрчил эхлэв. | d. 1755 он |
- A. 1d, 2b, 3c, 4a
B. 1a, 2b, 3c, 4d
C. 1b, 2c, 3a, 4d
D. 1c, 2b, 3d, 4a
E. 1c, 2d, 3a, 4b

27.

27. Манж, Хаант Орос хоёр улс Буриад монголчуудыг Оросын харьяат болгосон гэрээг хэзээ, хаана хийсэн бэ? /1 оноо/

- A. 1688 онд Ар Элстэйд
B. 1691 онд Долоон нуурт
C. 1689 онд Нэрчүд
D. 1856 онд Эрхүүд
E. 1913 онд Бээжинд

28.

28. Оросын хаан Ижил мөрний сав газарт суурьших Торгуудын Хо өрлөгийн хүсэлтийг хүлээн авсан шалтгааныг олно уу? /2 оноо/

- A. Торгуудын нүүдлийг зогсоох
- B. Хаант Орос улс өмнөд хилээ хамгаалах хүч болгон ашиглах
- C. Хо өрлөг Оросын хаанд их хэмжээний бэлэг сэлт өгсөн
- D. Олон адуутай ирсэн
- E. Ижил мөрний хөндийн хүн амыг нэмэгдүүлэх

29.

1680-аад оны дундуур Халхын Түшээт хан, Засагт хан нар юунаас болж тэмцэлдсэн бэ? /1 оноо/

- | | | |
|------------------|------------------|-------------------|
| A. Шашнаас | B. Газар нутгаас | C. Харьяат нараас |
| D. Мал сүргээсээ | E. Аль нь ч биш | |

30.

XVII-XX зууны эхэн үе нь Монголын түүхийн аль үе вэ? /2 оноо/

- | | |
|----------------------------|--------------------|
| A. Дөчин, Дөрвөн хоёрын үе | B. Дундад зууны үе |
| C. Сэргэн мандалтын үе | D. Социализмын үе |
| E. Манжийн эрхшээлийн үе | |

31.

31. 1755-1758 оны Манжийн эсрэг Халх монголчуудын бослогын удирдагчдад хэн нь хамаарахгүй вэ? /1 оноо/

- | | |
|-------------------------|------------------------|
| A. Хойдын Амарсанаа | B. Хотгойдын Чингүнжав |
| C. Түшээт хан Ямпилдорж | D. Засагт хан Балдир |
| E. Сэцэн хан Манибадар | |

32.

. Манжийн эсрэг тэмцсэн Халх монголчуудын бослого дарагдсан гол шалтгаан нь юу вэ?
/2 оноо/

- A. Халхын ноёдод Манжийн хаан их хэмжээний бэлэг өгсөн
- B. Халхын ноёд Манжийн их цэргийн сургаар Чингүнжаваас салж явсан
- C. Хаант Орос цэргийн тусламж үзүүлээгүй
- D. Улиастайн жанжин Цэнгүнжав Манжид дагаар орсон
- E. II Богд Жавзандамба хутагтыг Манжийн хаан хороосон

33.

. 1911 онд Хаант Орос улсаас тусламж гуйхаар явсан Монголын төлөөлөгчид хэн бэ?
/1 оноо/

- A. С.Данзан, Д.Чагдаржав
- B. Сайн ноён хан Намнансүрэн, Түшээт хан Дашням
- C. Шанзудба Бадамдорж, зайсан Цэрэн-Осор
- D. Чин ван Ханддорж, зайсан Цэрэн-Осор
- E. Чин ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд, гүн Хайсан

34.

34. 1911 оны 12 сарын 29-нд VIII Богд Жавзандамба хутагтыг Монгол улсын хаанаар өргөмжилж, тусгаар тогтнолоо тунхаглан зарлаж, төр улсаа сэргээн мандуулсан “Тусгаар тогтнолын баяр”-ын өдрийг хэдэн оноос бүх нийтээрээ тэмдэглэх болсон бэ?
/1 оноо/

- | | | |
|------------|------------|------------|
| A. 1990 он | B. 1921 он | C. 1925 он |
| D. 2011 он | E. 2016 он | |

35.

35. “Зарлигаар тогтоосон Монгол улсын шастир” хэмээх улсын албан түүхийг хэдэн онд бичсэн бэ?
/1 оноо/

- | | | |
|------------|------------|------------|
| A. 1917 он | B. 1921 он | C. 1913 он |
| D. 1915 он | E. 1918 он | |

36.

36. 1914 онд байгуулагдсан Улсын хурлын Дээд танхимд ямар албан тушаалтай хүмүүс суудаг байсан бэ? /2 оноо/

- A. Дөрвөн аймгийн хан, яамдын сайд, эрдэмтэд
- B. Яамдын дэс түшмэл, эх зохиогч түшмэд
- C. Яамдын тэргүүн сайд, дэд сайд, ван, бэйл, бэйс, гүн, засгууд, бүгдийн дарга
- D. Бүгдийн дарга, суурин жасааны түшмэл, аймгийн жанжин
- E. Хошууны ноёд, эрдэмтэд

37.

Доорх хүмүүсийн нэрс юуг илэрхийлж байна вэ? /2 оноо/
Д.Бодоо, Д.Данзан, Д.Сүхбаатар, Д.Пунцагдорж, Н.Магсаржав

- A. Ардын Засгийн газрын яамдын анхны сайд нар
- B. МАН-ын Төв хорооны анхны гишүүд
- C. ЗОУ-аас тусламж гуйхаар явсан нууц бүлгэмийн төлөөлөгчид
- D. Зүүн хүрээний бүлгэмийн гишүүд
- E. Ардын их хурлын тэргүүлэгчид

38.

Судар бичгийн хүрээлэнгийн анхны эрдэмтдэд хэн нь хамаарахгүй вэ? /1 оноо/
A. С.Жамьян B. Д.Нацагдорж C. Ж.Цэвээн
D. Б.Буянчуулган E. Л.Дэндэв

39.

39. Ардын засгийн газраас эзэн хамжлагын харилцааг халах түүхэн шийдвэр гаргаж, ноёд тайж нарын хамжлага захирах эрхийн тамгыг хураан авсны түүхэн ач холбогдлыг зөв тодорхойлсон нь аль вэ? /2 оноо/

- A. Ард олныг ноёдын эрх мэдлээс чөлөөлсөн ардчилсан өөрчлөлт болсон
- B. Ард олны амьдралыг дээшлүүлж, мал сүргийг өсгөсөн.
- C. Засгийн бүх эрх мэдэл ард түмэнд шилжсэн.
- D. Иргэдийн эрх, эрх чөлөөг тунхагласан.
- E. Хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийн суурь тавигдсан.

40.

40. 1924 оны Үндсэн хуулийн шинэ төслийг боловсруулсан комиссын гишүүдийг сонгоно уу? /1 оноо/

- A. Б.Цэрэндорж, А.Амар, Н.Жадамба
- B. П.Всесвятский, А.Бурдуков, И.Майский
- C. Н.Магсаржав, Д.Бодоо, П.Всесвятский
- D. Б.Цэрэндорж, Ж.Цэвээн, Э.Ринчино, П.Всесвятский
- E. Н.Магсаржав, Ж.Цэвээн, Ч.Бат-Очир

41.

1924 оноос Монголын нийслэлийг юу гэж нэрлэдэг болсон бэ? /1 оноо/

- | | |
|------------------|--------------------|
| A. Нийслэл Хүрээ | B. Улаанбаатар хот |
| C. Их Хүрээ | D. Өргөө |
| | E. Нийслэл хот |

42.

42. Шинэ эргэлтийн бодлогын жилүүдэд кино дэлгэцийн урлагийн хөгжилд гарсан дэвшил нь юу байсан бэ? /1 оноо/

- A. 1934 оны 9-р сарын 1-нээс радио нэвтрүүлэг явуулах болсон явдал
- B. Төв театрын тайзнаа 1934 онд “Учиртай гурван толгой” жүжгийг тоглосон явдал
- C. 1945 онд “Цогт тайж” уран сайхны кино дэлгэцнээ гарсан явдал
- D. 1935 онд “Монгол кино” үйлдвэр байгуулагдаж, дараа жил нь “Монгол хүү” гэсэн анхны уран сайхны кино дэлгэцнээ гарсан явдал
- E. Дээрх бүгд зөв

43.

43. Шинэ эргэлтийн бодлогын үр дүнд 1932 онд 18.8 сая байсан мал сүргийн тоо 1940 он гэхэд 26.2 саяд хүрсэн нь хэдэн хувиар өссөн үзүүлэлт вэ? /2 оноо/

- A. 20%
- B. 39%
- C. 11%
- D. 46%
- E. 17%

44.

44. 1932 оны 6-р сарын 29-30-ны хооронд болсон МАХН-ын Төв хороо, Хянан байцаах төв комиссын хамтарсан онц III бүгд хурлаар БНМАУ-ын хөгжлийн чиг хандлагыг юу гэж тодорхойлсон бэ? /2 оноо/

- A. Хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх
- B. ЗОУ-ын хөгжлийн загвараар хөгжих
- C. Капиталист бус хөгжлийн замаар хөгжих
- D. Социалист чиг хандлагаар хөгжих
- E. Үндэсний ардчилсан чиг шугамаар хөгжих

45.

45. 1945 оны Ялтын бага хурал дээр ЗХУ, АНУ, Их Британий удирдагчид Монголын талаар ямар тохиролцоонд хүрсэн бэ? /1 оноо/

- A. “Гадаад Монголын статус кво”-г хүлээн зөвшөөрөх
- B. Францаар Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх
- C. Японы эсрэг дайнд БНМАУ-ыг оролцуулах
- D. Дорнод хятадын төмөр замыг БНМАУ-д түрээслүүлэх
- E. Монголын нэгдсэн улс байгуулахыг хүлээн зөвшөөрөх

46.

46. БНМАУ-д социализм байгуулж дуусгах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд “нийгмийн өмч бий болгож, нэгнээ мөлжих явдлыг устгах ёстой” хэмээн үзэж ямар аж ахуйг “эдийн засаг дахь феодализмын үлдэгдэл” гэж тодорхойлсон бэ? /1 оноо/

- A. Тахиа гахайн аж ахуй
- B. Тариалангийн аж ахуй
- C. Ардын аж ахуй
- D. Худалдаа, гар урлал
- E. Эрчимжсэн мал аж ахуй

47.

47. Монгол улс НҮБ-ийн бүрэн эрхт гишүүн болсны 60 жилийн ой хэзээ тохиох вэ? /1 оноо/

- A. 2022. 12. 01
- B. 2020. 09. 17
- C. 2019. 10. 27
- D. 2021. 06. 01
- E. 2021. 10. 27

48.

48. Монгол улс НҮБ-ийн бүрэн эрхт гишүүн болсныхоо дараа дэлхий дахинд тулгамдсан асуудлуудаас ямар чиглэлд идэвхтэй оролцож байсан бэ? /2 оноо/

- A. Улс түмнүүдийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг зогсоох
- B. Байгаль орчны бохирдол, хүнсний аюулгүй байдлыг хангах
- C. Хүлэмжийн хийн хэмжээг бууруулах
- D. Тогтвортой хөгжлийг хангах
- E. Шашин хоорондын мөргөлдөөнийг зогсоох

49.

49. 1989 оны 12-р сарын 10-нд болсон Монголын Ардчилсан холбооны анхны цуглаан хаана болсон бэ? /1 оноо/

- A. МАХН-ын Төв байрны өмнө
- B. Сүхбаатарын талбайд
- C. Үйлдвэрчний соёлын ордны өмнө
- D. Төрийн ордны ар талд
- E. Залуучуудын соёлын төвийн үүдэнд

50.

50. 1990 оны 5-р сард батлагдсан “Улс төрийн намуудын тухай хууль”-ийн ач холбогдол нь юу вэ? /1 оноо/

- A. Монголын Ардчилсан нам байгуулагдав.
- B. Монголд олон намын тогтолцоо бий болов.
- C. Улсын бага хурлыг байгуулав.
- D. Ерөнхийлөгчийн албан тушаалыг бий болгов.
- E. МАХН-ын Улс төрийн товчоог огцруулав.

51.

51. 1990 оны анхны олон намын оролцоотой, чөлөөт ардчилсан сонгуулийн үр дүнд байгуулагдсан АИХ хэдэн депутаттай болсон бэ? /1 оноо/

- A. 357
- B. 50
- C. 76
- D. 422
- E. 32

52.

1992 оны Үндсэн хуулийн эрхэм зорилгыг буруу тодорхойлсон нь аль вэ? /2 оноо/

- A. Үндэсний эв нэгдлийг сэргээж, үндсэрхэг үзлийг дэлгэрүүлэх
- B. Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх
- C. Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх
- D. Хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэх
- E. Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх

53.

53. 1990 оноос Монголын ард түмэн эх түүх, өвөг дээдэс, өв соёлоороо бахархах, сэргээн хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх үндэсний үзэл, ухамсар сэргэсний илрэл аль вэ? /2 оноо/

- A. Шинэ оны баярыг чөлөөтэй тэмдэглэх болсон
- B. Жил бүр Ардын хувьсгалын баярыг тэмдэглэх болсон
- C. Хилс хэргээр хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх болсон
- D. Монголын нууц товчоо зохиогдсоны 750 жилийг ойг тэмдэглэсэн
- E. Цагаан сарын баярыг малчид тэмдэглэх болсон

54.

54. Монгол улс төрийн ордондоо Их Монгол улсын төрийн ямар бэлгэдлийг нь сэргээн залж, улсын баяр наадмаар төв цэнгэлдэх хүрээлэнд байрлуулдаг вэ? /1 оноо/

- A. Дөрвөн хөлт хар туг
- B. Есөн хөлт Цагаан туг
- C. Чингис хааны хөрөг
- D. Алаг туг
- E. Цагаан шонхор шувууны дүрс бүхий туг

55.

55. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу?

Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нэгдмэл байдлыг хамгаалан бататгах нь үндэсний аюулгүй байдлыг хангах нөхцөл мөн. /1 оноо/

- A. Хоёрдогч
- B. Гадаад
- C. Дотоод
- D. Язгуур
- E. Анхдагч

56.

Монгол улсад АНУ-ын ерөнхийлөгч Жорж Буш хэдэн онд айлчилсан бэ? /1 оноо/
A. 2012 B. 2002 C. 2006 D. 1991 E. 2014

2.1

2.1. Чингис хааны эсгий туургатан Монгол аймаг, улсуудыг нэгтгэсэн он цагийг зөв харгалзуулна уу? /6 оноо/

- | | |
|------------|--------------|
| a. 1197 он | 1. Татар |
| b. 1201 он | 2. Хэрэйд |
| c. 1202 он | 3. Ойн иргэд |
| d. 1203 он | 4. Найман |
| e. 1204 он | 5. Тайчууд |
| f. 1207 он | 6. Жүрхин |

2.2

Дараах ойлголтуудыг утгаар нь зөв харгалзуулна уу? /6 оноо/

- | | |
|--|------------------|
| a. 1634 онд зохиогдов. | 1. Шар тууж |
| b. 1587 онд Аюуш гүүш зохиов. | 2. Соёмбо үсэг |
| c. Эх түүхээ мэдэхгүй хүн ойд төөрсөн сармагчин лугаа адил | 3. Тод үсэг |
| d. Саган сэцэн зохиов. | 4. Алтан товч |
| e. Ойрадын Зая бандид Намхайжамц зохиов. | 5. Али гали үсэг |
| f. “Өөрөө буй болсон гэгээн үсэг” гэсэн утгатай | 6. Эрдэнийн товч |

2.3

1. 1921 оны хувьсгалын түүхэн гол үйл явдлуудыг зөв харгалзуулна уу? /6 оноо/
- | | |
|------------------|---|
| a. 1921.03.13 | 1. Ардын засгийн газар байгуулагдав. |
| b. 1921.07.10 | 2. Цэргийн нэрийг Ардын журамт цэрэг хэмээн өөрчлөв. |
| c. 1921.02-р сар | 3. Богд хааныг хэмжээт эрхт хаанаар өргөмжлөв. |
| d. 1921.07.11 | 4. Ардын журамт цэрэг Хиагтыг гамин цэргээс чөлөөлөв. |
| e. 1921.03.12 | 5. Ардын түр засгийн газрыг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав. |
| f. 1921.03.18 | 6. Д.Сүхбаатарыг цэргийн жанжнаар томилов. |

2.4

1. Зөв харгалзуулна уу? /6 оноо/
- | | |
|---|---------------|
| a. МоАХ-ны 10 гишүүн Сүхбаатарын талбайд өлсгөлөн зарлав. | 1. 1989.12.07 |
| b. Ховдод улс төрийн анхны жагсаал цуглаан болов. | 2. 1990.03.23 |
| c. Нам, төрийн удирдлагатай “Дугуй ширээ”-ний хэлэлцээр хийв. | 3. 1989.03.10 |
| d. МАХН бол төр, нийгмийг удирдан чиглүүлэгч гэх 1960 оны Үндсэн хуулийн заалтыг хүчингүй болгов. | 4. 1990.03.12 |
| e. МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцров. | 5. 1990.03.09 |
| f. Улс төрийн нам хүчнүүд хамтарсан тунхаглал гаргав. | 6. 1990.03.07 |

№	зөв хариу	Оноо
1	C	1
2	B	2
3	E	1
4	D	1
5	B	2
6	D	1
7	D	2
8	E	1
9	A	1
10	D	1
11	B	1
12	E	2
13	A	1
14	C	2
15	B	2
16	D	1
17	C	1
18	B	2
19	E	1
20	A	1
21	D	2
22	A	1
23	B	1
24	D	1
25	A	1
26	E	2
27	C	1
28	B	2
29	C	1
30	E	2

№	зөв хариу	Оноо
31	A	1
32	B	2
33	E	1
34	D	1
35	E	1
36	C	2
37	A	2
38	B	1
39	A	2
40	D	1
41	B	1
42	D	1
43	B	2
44	E	2
45	A	1
46	C	1
47	E	1
48	A	2
49	E	1
50	B	1
51	D	1
52	A	2
53	D	2
54	B	1
55	E	1
56	C	1

№	зөв хариу		Оноо
2.1	a	6	1
	b	5	1
	c	1	1
	d	2	1
	e	4	1
	f	3	1
2.2	a	4	1
	b	5	1
	c	1	1
	d	6	1
	e	3	1
	f	2	1
2.3	a	5	1
	b	1	1
	c	6	1
	d	3	1
	e	2	1
	f	4	1
2.4	a	6	1
	b	1	1
	c	5	1
	d	2	1
	e	4	1
	f	3	1